



ЛОДОЙН ТАВХАЙ

Улаанбаатар хотын захиргааны дарга
1939.05-1939.11 он

Богд хан уулын аймаг, одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын /1942 онд Төв аймгаас шилжиж ирсэн сум/ нутагт 1910 онд төрсөн. 16 настайдаа монгол бичигт суралцан хошуу тамгын газар бичээч, Богдхан уулын аймгийн МХЗЭ-ийн хорооны даргаар ажиллаж байгаад ЗСБНХУ-ын Москва хотноо КУТВ-т суралцаж, 1930 онд төгсөж ирээд Архангай аймагт гарсан эсэргүү хөдөлгөөнийг дарах ажилд оролцохоор МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр цэргийн ангид очиж намын товчооны даргаар ажиллажээ. Улмаар аймгийн Намын хорооны суртлын хэлтсийн эрхлэгчээр томилогдож эсэргүү бослого гаргагчидтай хийсэн том жижиг тулалдаанд 20 гаруй удаа оролцон, нутгийн ард олонд ухуулга таниулга хийж, орон нутгийн байдлыг тайван тогтвортой болгох ажилд идэвхтэй оролцож явжээ.

1932 оны сүүлчээс Улаанбаатар хотын намын хорооны суртлын хэлтсийн эрхлэгч, Төв, Завхан аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга, 1937 оноос Улаанбаатар хотын намын хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байв. Энэ хугацаанд МАХН-ын IX их хуралд төлөөлөгчөөр

оролцож, Төв хорооны гишүүнээр сонгогдсон байна.

1939 оноос Үйлдвэр худалдааны яамны дэд сайд, жинхэнэ сайдаар ажиллаж байхдаа 1939 онд болсон улсын ударникчуудын анхдугаар зөвлөгөөний хуралд илтгэл тавьж байв.

Ардын сайд нарын зөвлөлийн 1939 оны тавдугаар сарын 9-ний 52 дугаар тушаал, улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор Хот захирах яамыг Хотын захиргаа болгон өөрчилж даргаар нь Л.Тавхайг томилон ажиллуулж, удалгүй мөн оны 11 дүгээр сард чөлөөлсөн байна.

1940 оны наймдугаар сард хилс хэрэгт баривчлагдан шийтгүүлсэн бөгөөд 1966 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 014 дүгээр тогтоолоор цагаатгагджээ.